



НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН ТУШААЛ

2009 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Протез, ортопедийн хэрэгслийн жишиг үнийг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 162 дугаар тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 1.4 дэх заалт, “Ахмад настанд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 1.4-т заасныг үндэслэн **ТУШААХ нь :**

1. Нийгмийн халамжийн сангаас хөнгөлөлттэй үнээр олгох протез, ортопедийн хэрэгслийн жишиг үнийг хавсралтаар баталсугай.

2. “Нийгмийн халамжийн тухай”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай”, “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай” хуулийн дагуу тусламж, хөнгөлөлт, үйлчилгээнд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настанд гадаад, дотоодод хийлгэсэн болон худалдан авсан протез, ортопедийн хэрэгслийн хөнгөлөлтийг үзүүлэхдээ энэхүү жишиг үнийг баримталж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар /Д.Баярсайхан/, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж, дүнг жил бүрийн IY улиралд Сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулж байхыг Мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээний газар /Ц. Амартөгс/, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар /Д.Баярсайхан/-т тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2007 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 48 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Handwritten signature of T. Gandi

Т.ГАНДИ

63

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн
сайдын 2009 оны 01 дүгээр сарын 30-ны
өдрийн 24 дугаар тушаалын хавсралт

ПРОТЕЗ-ОРТОПЕДИЙН ХЭРЭГСЛИЙН ЖИШИГ ҮНИЙН ЖАГСААЛТ

№	Протез, ортопедийн хэрэгслийн нэр	Үнэ /төгрөгөөр
А. ПРОТЕЗИЙН ХЭРЭГСЭЛ		
А-1 ДООД МӨЧНИЙ ПРОТЕЗ		
1.	Шилбэ, тавхайн протез	350.000-400.000
2.	Дунд чөмөгний протез	450.000-500.000
3.	Сүүж, түнхний протез	600.000-650.000
4.	Тавхайн урд хэсгийн протез /башмачок/	50.000-80.000
5.	Өвдөгний тулгууртай шилбэний протез	450.000-500.000
6.	Хиймэл түнхний үе	1500.000-2000.000
7.	Хиймэл өвдөгний үе	4000.000
А-2 ДЭЭД МӨЧНИЙ ПРОТЕЗ		
8.	Мөр, бугалганы протез	350.000-400.000
9.	Шууны протез	250.000-300.000
10.	Сарвууны протез	100.000-150.000
11.	Гарын хурууны протез	10.000-15.000
А-3 БУСАД ПРОТЕЗИЙН ХЭРЭГСЛҮҮД		
12.	Нүдний хиймэл болор	110.000-150.000
13.	Хиймэл эрүү	120.000-180.000
14.	Шилэн нүд	60.000-70.000
15.	Хуванцар нүд	45.000-55.000
16.	Хиймэл буйл	20.000-30.000
17.	Хиймэл шүд	30.000-70.000
Б. ОРТОПЕДИЙН ХЭРЭГСЭЛ		
Б-1 СОГОГ ЗАСАХ ГУТАЛУУД		
18.	Өвлийн гутал	60.000-65.000
19.	Хавар, намарын гутал	50.000-55.000
20.	Зуны гутал	40.000-50.000
Б-2 ТӨРӨЛ БҮРИЙН УЛАВЧУУД		
21.	Өндөрлөгтэй улавчууд	10.000-15.000
22.	Пронатор, супинатор улавч	15.000-25.000
Б-3 НУРУУНЫ ХАМГААЛАЛТ		
23.	Нурууны ширэн хамгаалалт	60.000-65.000
24.	Нурууны даавуун хамгаалалт	25.000-30.000
25.	Нурууны хуванцар хамгаалалт	150.000-200.000
Б-4 ТӨРӨЛ БҮРИЙН ЧИГҮҮД		
26.	Хөлийн аппарат урт	150.000-200.000
27.	Хөлийн аппарат богино	90.000-100.000
28.	Гарын чиг	20.000-80.000
29.	Хүзүүвч	15.000-25.000
Б-5 ОРТОПЕДИЙН БУСАД ХЭРЭГСЛҮҮД		
30.	Павликийн дөрөөвч	10.000-15.000
31.	Ивэрхийн даруулга	10.000-15.000
32.	Бөөрний бандааж	10.000-15.000
В. СЭРГЭЭН ЗАСАЛТЫН ТУСЛАХ ХЭРЭГСЛҮҮД		
В-1 ТӨРӨЛ БҮРИЙН ТАЯГНУУД		
33.	Модон таяг /хос/	10.000-15.000
34.	Төмөр суга таяг /хос/	30.000-40.000
35.	Тохойн тулгууртай таяг /хос/	30.000-40.000
36.	Гар таяг	8.000

37.	Цагаан таяг /мэдрэгчтэй хараагүй хүнд зориулсан/	25.000-35.000
В-2 БУСАД ХЭРЭГСЭЛ		
38.	Алхуулагч	20.000-50.000
39.	Тэргэнцэр /насанд хүрэгсэд/	100.000-150.000
40.	Тэргэнцэр /хүүхэд/	150.000-200.000
41.	Хараагүй хүний брайлын хэрэгсэл /брайль цаас 300 ширхэг, брайль шугам, бичгийн машин, брайль тэмдэглэлийн дэвтэр/	60.000-100.000
42.	Магнитофон	40.000-60.000
43.	Сонсголын аппарат /дигитал/	270.000-350.000
44.	+5,- 5 ба түүнээс дээш харааны шил	10.000
45.	Контактны линз	80.000-100.000
46.	Ярьдаг цаг	15.000-25.000
47.	Брайль цаг	18.500-30.000
48.	Ярьдаг даралтын аппарат	150.000
49.	Ярьдаг халууны шил	30.000-50.000
50.	Бичиг томруулагч линзэн шил	15.000-30.000
51.	Радио хүлээн авагч	30.000-50.000
52.	Компьютерийн ярьдаг программ хангамж, нэмэгдэл төхөөрөмж	200.000
53.	Хөтөвч	20.000-30.000

-----oOo-----